



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 10 сарын 04 өдөр


Дугаар 5/15

Мандалговь

**Бат-Эрдэнэ овогтой Наранцэцэгийг
ажилд томилох тухай**

Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх заалт, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн Сайдын 2021 оны А/63 тоот тушаалын 10 дугаар хавсралт, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын хамтарсан 34/31 тоот тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Бат-Эрдэнэ овогтой Наранцэцэгийг 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн Мал үржлийн албаны Малын удам зүйн үнэлгээ, цөм сүрэг, үүлдэр ашиг шимийн сайжруулалт, үржүүлэг технологийн ажил үйлчилгээ, итгэмжлэлийн асуудал хариуцсан мэргэжилтнээр томилсугай.
2. Б.Наранцэцэгийн цалинг Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын дагуу ТЗ-5-4 ангиллаар, үндсэн цалинг 754867 төгрөг, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 10 хувиар, зэрэг дэвийн нэмэгдлийг 10 хувиар тооцож олгохыг ахлах нягтлан бодогч (Б.Энхдөл)-д зөвшөөрсүгэй.
3. Б.Наранцэцэгтэй холбогдох албан бичиг баримт, эд хөрөнгийг тэмдэглэл үйлдэн 2021 оны 10 сарын 04 өдөр хүлээлцэхийг Мал үржлийн албаны дарга (Ж.Батбилэг), Мал үржлийн албаны мэргэжилтэн (Э.Уугандорж), Нярав, архив хариуцсан ажилтан (П.Мөнхсүх) нарт үүрэг болгосугай.

ДАРГА  Б.МӨНХЖАРГАЛ



482110058